

# **“СҮҮ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2017 оны 04-р сарын 28-ны өдөр

№ 01

Улаанбаатар хот

“Сүү” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Монгол Улсын Компанийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хороо, “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-иас тус тус баталсан холбогдох журмууд болон “Сүү” ХК-ийн Дүрмийг тус тус удирдлага болгон явууллаа.

Хурлын цаг: 15:00-17:30,

Хурлын байршил: “Сүү” ХК-ийн байр,

Хурлын дарга: Б.Гантулга,

Хурлын нарийн бичгийн дарга: Б.Цэрэндорж,

Хурлын ирц: Саналын эрх бүхий 248,012,729 ширхэг хувьцаа буюу нийт хувьцааны 72,1%,

Хуралд урилгаар оролцсон хүмүүс:

- “Сүү” ХК-ийн Санхүүгийн албаны дарга В.Шинэцэцэг, Эдийн засагч П.Эрдэнэбаатар, Санхүүгийн шинжээч, эдийн засагч Б.Отгонбаатар,

**Хэлэлцэх асуудал:**

1. Компанийн 2016 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай асуудал,
2. ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийн хугацааг үргэлжлүүлэх тухай асуудал,
3. Ногдол ашгийн талаар Хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл хүргэх тухай асуудал,

**Хэлэлцсэн нь:**

1. Компанийн 2016 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай асуудал,
2. ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийн хугацааг үргэлжлүүлэх тухай асуудал,
3. Ногдол ашгийн талаар Хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл хүргэх тухай асуудал,

**Танилцуулсан нь:**

**Нарийн бичгийн дарга:**

Та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтгая. “Сүү” ХК-ийн 2017 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал эхэлж байна.

Та бүхэд ээлжит хурлын ирцийн мэдээг танилцуулая.

“Сүү” ХК-ийн саналын эрх бүхий нийт 344,000,000 ширхэг хувьцааны 72,1% болох нийт 248,012,729 ширхэг саналын эрхтэй хувьцаа эзэмшигчид хуралд хүрэлцэн ирсэн байгаа бөгөөд Монгол Улсын Компанийн тухай хуульд заасны дагуу компанийн саналын эрх бүхий хувьцааны 50-аас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хувьцаа эзэмшигчдийн хуралд хүрэлцэн ирсэн байх тул хурлын ирц бүрдсэн байна.

**Нарийн бичгийн дарга:** Та бүхэнд “Сүү” ХК-ийн ТУЗ-ийн 2017 оны 03-р сарын 15-ны өдрийн № 02 тоот “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай” тогтоолын дагуу батлагдсан хуралдааны дэгийг танилцуулая.

- Хуралдааны дэгийг танилцуулав.

Мөн та бүхэнд “Сүү” ХК-ийн ТУЗ-ийн 2017 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн №02 тоот Тогтоолын дагуу томилогдсон Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дарга хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хувьцаа эзэмшигчдийн хурлыг даргалах боломжгүй болсон тул Компанийн тухай хуулийн 60.5, 80.2 дах хэсгүүд болон “Сүү” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2017 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр хуралдсан хурлын шийдвэрийн дагуу “Сүү” ХК-ийн “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал”-ын дарга шинээр томилогдсон буюу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар “Сүү” ХК-ийн ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирал Б.Гантулга томилогдсон болохыг танилцуулъя.

- Тогтоолыг танилцуулав.

**Хувьцаа эзэмшигчдын ээлжит хурлын дарга:** Сайн байцгаана уу? Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргье. Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс баталсан тогтоолын дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлыг баталсны дагуу бид энэ удаагийн хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэж батлах ёстой байгаа. Үүнд:

1. Компанийн 2016 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай асуудал,
2. ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийн хугацааг үргэлжлүүлэх тухай асуудал,
3. Ногдол ашгийн талаар Хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл хүргэх тухай асуудал,

Иймд хэлэлцэх эхний асуудлын дагуу Компанийн 2016 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг миний бие танилцуулах байгаа. Танилцуулга хийсний дараагаар та бүхэн хэлэлцэх асуудалтай холбоотой асуух зүйлс байвал асууж болно.

- Хувьцаа эзэмшигчдын ээлжит хурлын дарга, “Сүү” ХК-ийн ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирал Б.Гантулга Компанийн 2016 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийн талаар танилцуулга хийв.

**Хувьцаа эзэмшигчдын ээлжит хурлын дарга:** Та бүхэнд хэлэлцэж байгаа асуудалтай холбоотойгоор асуух зүйл байна уу?

Асуулт:

Хувьцаа эзэмшигч Стандарт инвестмент ҮЦК-ийн төлөөлөгч Б.Эрдэнэжаргал: 2016 оны хувьд ханшийн зөрүүнээс компани гол алдагдал хүлээсэн гэж ярьлаа. Энэ онд ханшийн зөрүүний алдагдал хүлээхгүй гэж тооцож байгаа юу? Мөн 2017 оны компанийн цэвэр ашгийн хэмжээг хэдэн төгрөгөөр тооцож байна?

Хариулт:

Хувьцаа эзэмшигчдын ээлжит хурлын дарга: Бидний хувьд ам.долларын төгрөгтэй харьцах ханшийг 2,450 төгрөгөөр тооцсон байгаа. Ерөнхийдөө эдийн засгийн нөхцөл байдлыг ажиглахад энэ онд ханшийн зөрүүний алдагдал харьцангуй бага гарна гэж тооцоолол хийсэн. Арилжааны банкуудын судалгаагаар оны сүүлээр ам.долларын төгрөгтэй харьцах ханшийг 2,300 төгрөг хүртэл буурч магадгүй гэсэн таамаглал байгаа. Хэрэв энэ таамаглал бодитой хэрэгжвэл ашигт ажиллагаа маань илүү нэмэгдэнэ гэж харж байгаа. Энэ онд төлөвлөсөн ашгийн хэмжээний хувьд ханшийн алдагдал болон хүүгийн зардлыг хасаж тооцвол 8,0 тэрбум төгрөгийн ашигтай ажиллах боломж байгаа.

Асуулт:

Хувьцаа эзэмшигч:

2017 оны хүүгийн зардлыг өсгөсөн харагдаж байна. Энэ зардал дотор IFC-гийн хүүгийн зардлаас гадна ямар ямар зардлууд багтаж байгаа вэ?

Хариулт:

Хувьцаа эзэмшигчдын ээлжит хурлын дарга: Бид ам.долларын зээлийг төгрөгийн зээлд хөрвүүлж гэж төлөвлөөд байгаа. Бидний бас нэг бодож байгаа зүйл маань Хөрөнгийн бирж дээр Бонд гаргах асуудал байгаа. Бонд гаргах сонирхол нь аль нэг арилжааны банкнаас хараат байхаа болих давуу талтай. Өнөөдрийн байдлаар Засгийн газрын бондын хүү эрчимтэй буурч байна. Хэрэв энэ эрчээ алдахгүй буурвал манай компани бонд гаргах нөхцөл боломж бүрдэх юм.

Асуулт:

Хувьцаа эзэмшигч Баатар:

Компани ногдол ашиг тараах боломж байгаа юу?

Хариулт:

Хувьцаа эзэмшигчдын ээлжит хурлын дарга: Одоогийн үйлчилж байгаа IFC, BIO, PROPARCO байгууллагуудтай байгуулсан гэрээгээр хүлээсэн үүргийн хувьд бид 2019 он хүртэл ногдол ашиг тараах боломжгүй байгаа. Бидний хувьд энэ зээлийг хугацаанаас нь өмнө төлөөд, гэрээний үүргээсээ гарчихвал ногдол ашиг тараах гэсэн төлөвлөгөөтэй байгаа. Бид энэ хурлаараа энэ асуудлыг ярилцаад хэрэв хугацаанаас өмнө дээрх гэрээний үүргээсээ гарчихвал ногдол ашиг тараах, түүнийг зохион байгуулах эрхийг ТУЗ-д олгож болно.

Асуулт:

Хувьцаа эзэмшигч:

Ногдол ашгийг компанийн ашгийн хэдэн хувиар тооцож тараах боломжтой байгаа вэ?

Хариулт:

Хувьцаа эзэмшигчдын ээлжит хурлын дарга: Компанийн баланс дээр өнөөдрийн байдлаар 20,0 тэрбум төгрөгийн ногдол ашиг хуримтлагдсан байгаа. Үүнээс эхний жилдээ буюу 2017 ондоо 3,0 тэрбум төгрөгийг ногдол ашиг болгон тараах гэсэн саналтай байгаа.

Асуулт:

Хувьцаа эзэмшигч Ганчимэг:

Компанийн үндсэн үйл ажиллагааны зардал өндөр байна. Энд гол зардлыг ямар зардал эзлэж байна? Гадаад зээлийг хэдэн онд төлж дуусгах вэ?

Хариулт:

“Сүү” ХК-ийн Санхүүгийн албаны дарга В.Шинэцэцэг: Үндсэн үйл ажиллагааны зардлыг өсгөж байгаа гол зардал нь гадаад валютын ханшийн өсөлт байгаа.

Хувьцаа эзэмшигчдын ээлжит хурлын дарга: Бид IFC, BIO, PROPARCO байгууллагуудаас 2011 онд авсан зээлийн эргэн төлөлтийг 2013 оноос хийж эхэлсэн, энэ зээлийн хугацаа нь 2019 он дуусах байгаа. Өнөөдрийн байдлаар нийт зээлийн 70%-ийг төлж дуусгаад байна. Үлдэгдэл нь 1,8 сая ам.доллар байгаа.

Хувьцаа эзэмшигчдын ээлжит хурлын дарга: Хувьцаа эзэмшигчдээс өөр асууж тодруулах зүйл байна уу?

Хувьцаа эзэмшигчид бүгд: Байхгүй.

Хувьцаа эзэмшигчдын ээлжит хурлын дарга: Хувьцаа эзэмшигчдээс өөр асууж тодруулах зүйл байхгүй бол хэлэлцэж байгаа эхний асуудалд саналын хуудсаар саналаа өгцгөөнө үү.

Нарийн бичгийн дарга: Та бүхэнд саналын хуудасны загварыг танилцуулая.

“Сүү” ХК-ийн ТУЗ-ийн  
2017 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн  
№02 тоот Тогтоолын хавсралт №4

**“СҮҮ” ХК-ИЙН “ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ЭЭЛЖИТ ХУРАЛ”-Д САНАЛ АВАХ ХУУДАС**

/Загвар/

“Сүү” ХК-ийн “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал” 2017 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 15:00 цагт “Сүү” ХК-ийн байранд болов.  
Хувьцаа эзэмшигчийн овог:..... нэр.....  
Хувьцаа эзэмшигчийн дансны дугаар:.....  
Регистрийн дугаар:.....  
Санал өгөх хувьцааны тоо:.....  
Бүртгэсэн /Үнэт цаасны компанийн нэр/.....

| Д/д | Санал өгөх асуудлын агуулга | Зөвшөөрсөн саналын тоо | Татгалзсан саналын тоо |
|-----|-----------------------------|------------------------|------------------------|
| 1.  | .....                       | .....                  | .....                  |

Хувьцаа эзэмшигч: .....

Санал авах хуудсыг ашиглах санамж:

Санал авах хуудсыг засварласан балласан тохиолдолд санал авах хуудас нь хүчингүйд тооцогдоно.

Санал авах хуудсыг хүчингүй болгосон  
шалтгаан:.....

Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчид бүгд: Саналын хуудсаар саналаа өгөв.

Нарийн бичгийн дарга: Дэгийн дагуу дараагийн хэлэлцэх асуудал ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийн хугацааг үргэлжлүүлэх тухай асуудал байгаа.

“Сүү” ХК-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.3 дах хэсэгт: “ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа нь 1 жил байх бөгөөд хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуульд заасан хугацаанд хуралдуулснаар бүрэн эрх үргэлжлэнэ” гэж заасны дагуу “Сүү” ХК-ийн ТУЗ-ийн хурал Монгол улсын Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлд заагдсан хугацаанд хуралдсан учир одоо ажиллаж байгаа “Сүү” ХК-ийн ТУЗ-ийн Гишүүдийн бүрэн эрхийн хугацаа компанийн дүрэмд заасны дагуу үргэлжлэх ёстой байгаа.

“Сүү” ХК-ийн ТУЗ-ийн гишүүдээр дараах нэр бүхий 12 хүн ажиллаж байгааг танилцуулъя.  
Үүнд:

| № | Овог, нэр     | Албан тушаал   |
|---|---------------|----------------|
| 1 | Д.Ганбаатар   | ТУЗ-ийн дарга  |
| 2 | Д.Цэрэнжигмэд | ТУЗ-ийн гишүүн |

|    |               |                           |
|----|---------------|---------------------------|
| 3  | Б.Түвшинтөгс  | ТУЗ-ийн гишүүн            |
| 4  | Д.Жамъян      | ТУЗ-ийн гишүүн            |
| 5  | Ц.Соёл-Эрдэнэ | ТУЗ-ийн гишүүн            |
| 6  | Д.Уянгалянхуа | ТУЗ-ийн гишүүн            |
| 7  | Б.Гантулга    | ТУЗ-ийн гишүүн            |
| 8  | Н.Бадамханд   | ТУЗ-ийн гишүүн            |
| 9  | Н.Цэрэндорж   | ТУЗ-ийн хараат бус гишүүн |
| 10 | Ш.Даваалимбэ  | ТУЗ-ийн хараат бус гишүүн |
| 11 | Г.Баяр        | ТУЗ-ийн хараат бус гишүүн |
| 12 | П.Мэндсайхан  | ТУЗ-ийн хараат бус гишүүн |

**Хувьцаа эзэмшигчдын ээлжит хурлын дарга:** Та бүхэнд хэлэлцэж байгаа асуудалтай холбоотойгоор асуух зүйл байна уу?

Асуулт:

Хувьцаа эзэмшигч Ганчимэг:

ТУЗ-ийн гишүүдийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл авах боломж байгаа юу?

Хариулт:

Хувьцаа эзэмшигчдын ээлжит хурлын дарга: Компанийн ТУЗ-ийн гишүүдийн хувьд 2012 оноос хойш тогтвортой үйл ажиллагаа явуулж байгаа хүмүүс байгаа. Эдгээр хүмүүсийн мэдээлэл олон нийтэд нээлттэй байгаа. Та бүхэн хүсвэл дэлгэрэнгүй мэдээлэл авч болно. ТУЗ-ийн зүгээс дараа, дараагийн Хувьцаа эзэмшигчдын хурлуудын зохион байгуулалтыг сайжруулах, цаашид ТУЗ-ийн үйл ажиллагааг компанийн засаглалын зарчимд нийцүүлэн, илүү идэвхижүүлэх тал дээр анхаарч ажиллах болно.

**Хувьцаа эзэмшигчдын ээлжит хурлын дарга:** Хувьцаа эзэмшигчдээс өөр асууж тодруулах зүйл байхгүй бол саналын хуудсаар саналаа өгцгөөнө үү.

Нарийн бичгийн дарга саналын хуудасны загварыг танилцуулав.

**Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчид бүгд:** Саналын хуудсаар саналаа өгөв.

**Нарийн бичгийн дарга:** Хурлын дэгийн дагуу Ногдол ашгийн талаар Хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл хүргэх ёстой байгаа. “Сүү” ХК нь 2011 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн № 29215 тоот “Зээлийн гэрээ”-ний дагуу IFC, BIO, PROPARGO байгууллагуудаас 6,000,000 /Зургаан сая/ ам.долларын зээл авсантай холбогдуулан, энэхүү зээлийн өрийг төлж дуустал буюу 2019 оныг хүртэлх хугацаанд хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахгүй байх тухай 2015 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн № 01 тоот “Сүү” ХК-ийн ТУЗ-ийн тогтоол гарсаныг жил бүрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулаад явж байгаа. Энэхүү тогтоолыг та бүхэнд танилцуулъя.

Тогтоолыг уншиж танилцуулав.

**Хувьцаа эзэмшигчдын ээлжит хурлын дарга:** Ерөнхийдөө түрүүнд гадаадын хөрөнгө оруулагчтай байгуулсан гэрээний дагуу компани ногдол ашиг тараах үндэслэл, нөхцөл бүрдэж өгөхгүй байгаа тухай тайлбарласан. ТУЗ-өөс цаашдаа жил болгон ногдол ашиг тараадаг болох бодлого баримталж байгаа. Ингэхийн тулд гол саад болоод байгаа гадаад зээлийн гэрээний үүргээсээ чөлөөлөгдөх асуудал байгаа. ТУЗ-ийн хувьд энэ жилдээ багтаад энэхүү зээлийг төлж барагдуулан, зээлийн гэрээний үүргээс чөлөөлөгдсөн нөхцөлд ногдол ашиг тараах нөхцөл бүрдэх бөгөөд энэ хурлаараа нийт хувьцаа эзэмшигчид энэхүү зээлийн үүргээс чөлөөлөгдсөн тохиолдолд ногдол ашиг тараах тухай шийдвэр гаргах тухай ТУЗ-ийн гаргасан саналыг дэмжвэл, саналыг хурлын тэмдэглэлдээ тусгах саналтай байна.

**Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчид бүгд:** Энэхүү хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг тараахад саад учруулаад байгаа гадаад зээлийн өрийг төлж барагдуулан, гэрээний үүргээс чөлөөлөгдсөн нөхцөлд, энэ ондоо багтаад ногдол ашиг тараах тухай шийдвэр гаргах ТУЗ-ийн гаргасан саналыг нийт хувьцаа эзэмшигчид дэмжиж, гар өргөв.

**Хувьцаа эзэмшигчдын ээлжит хурлын дарга:** Хувьцаа эзэмшигчдээс өөр асууж тодруулах зүйл байхгүй бол саналын хуудсаар саналаа өгцгөөнө үү.

Нарийн бичгийн дарга саналын хуудасны загварыг танилцуулав.

**Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчид бүгд:** Саналын хуудсаар саналаа өгөв.

**Хувьцаа эзэмшигчдын ээлжит хурлын дарга:** Одоо дэгийн дагуу хурал завсарлана. Үүний дараагаар тооллогын комисс тогтоол танилцуулна.

Хурал завсарлав.

**Хувьцаа эзэмшигчдын ээлжит хурлын дарга:** Тооллогын комисс тогтоол танилцуулна.

**Тооллогын комиссын дарга:** Тооллогын комисс хэлэлцэх асуудлуудтай холбоотойгоор, саналын хуудсаар авсан саналуудыг нэгтгэж дүнг гаргалаа. Одоо та бүхэнд дүнг таницуулая.

“Сүү” ХК-ийн “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал”-д хувьцаа эзэмшигчдээс ирүүлсэн санал хураалтаар, хэлэлцсэн эхний асуудал болох Компанийн 2016 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай асуудлаар нийт 247,984,442 ширхэг хувьцааны хүчинтэй санал гарч 23,151 хувьцааны хүчингүй санал гарсан байна.

Эхний хэлэлцсэн асуудал болох “Сүү” ХК-ийн 2016 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай асуудлыг нийт хувьцаа эзэмшигчдийн 99,999996% саналаар дэмжсэн байна.

Хэлэлцсэн асуудлаар гарсан Тооллогын комиссын тогтоолыг уншиж танилцуулав.

Дараагийн хэлэлцсэн асуудал болох ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийн хугацааг үргэлжлүүлэх тухай асуудлыг хэлэлцсэн санал хураалтаар нийт 247,964,752 ширхэг хувьцааны хүчинтэй санал гарч 23,101 хувьцааны хүчингүй санал гарсан байна.

Хоёр дахь хэлэлцсэн асуудал болох ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийн хугацааг үргэлжлүүлэх тухай асуудлыг нийт хувьцаа эзэмшигчдийн 99,99999% саналаар дэмжсэн байна.

Хэлэлцсэн асуудлаар гарсан Тооллогын комиссын тогтоолыг уншиж танилцуулав.

**Хувьцаа эзэмшигчдын ээлжит хурлын дарга:** Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарсан тогтоолуудыг уншиж танилцуулан хурал 17:30 цагт хаасныг мэдэгдэв.

**Тусгай тэмдэглэл:** “Сүү” ХК-ийн 2011 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн № 29215 тоот “Зээлийн гэрээ”-ний дагуу IFC, BIO, PROPARCO байгууллагуудаас авсан 6,000,000 /Зургаан сая/ ам.долларын зээлийг 2017 онд багтаан төлж, барагдуулан зээлийн гэрээний үүргээс чөлөөлөгдсөн нөхцөлд, ТУЗ-өөс хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг тараах тухай шийдвэр гаргах асуудлыг нийт хувьцаа эзэмшигчид дэмжив.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЫН ЭЭЛЖИТ  
ХУРЛЫН ДАРГА:

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЫН ЭЭЛЖИТ  
ХУРЛЫН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА:



/Б.ГАНТУЛГА/

/Б.ЦЭРЭНДОРЖ/